

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Азийн эмэгтэйчүүдийн төлөөх залбирал

Монгол Улс нь Зүүн Азийн эх газрын хойд хэсэгт байрладаг бөгөөд 1,564,000 м.кв газар нутагтайгаар дэлхийн хэмжээнд 18-д ордог. Энэ нь Солонгосын хойгийг 7 дахин багтаахаар хэмжээтэй юм. Монгол дахь TWR-ийн "Найдварын Эмэгтэйчүүд" (Women of Hope) үйлчлэл нь 2023 оны 9-р сард эхэлсэн бөгөөд “Найдварын Эмэгтэйчүүд” хөтөлбөр 2025 оны 1-р сараас эхлэн улс даяар FM радиогоор цацагдаж эхэлсэн. Хэдийгээр хөтөлбөр нь эхний шатандаа байгаа ч, нөлөө нь хурдан өргөжиж байгаа бөгөөд контентуудыг нийгмийн сүлжээ болон YouTube-р дамжуулан хүргэж байна. Энэхүү (үйлчлэл) нь эмэгтэйчүүдийн бие махбод, сэтгэл санаа болон сүнслэг хэрэгцээг хангаснаар амьдралын томоохон сорилтуудын дунд ч гэсэн Есүс Христэд итгэх итгэл, найдвар, хүчийг хуваалцахад чиглэж байна.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

хүчирхийлэл үйлдэгчдийг өөрчлөгдөхөд хүргээрэй. (Дуулал 82:3-4)

4. Бурхан минь, хүн төрөлхтний зүрх сэтгэлийг зөвхөн Та л өөрчилж чадна. Энэтхэгийн нийгмийн хандлага эмэгтэйчүүдийг хүндэлдэг, нэр төрийг нь дээдэлдэг, шударга ханддаг болохыг залбирч байна. (Сургаалт үгс 21:1)

5. Аав аа, Индонезид төрөлтийн үеийн эхийн нас баралт өндөр хэвээр байна. Засгийн газар ядуу жирэмсэн эмэгтэйчүүдэд үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх шийдвэрийг гаргах болтугай (Дуулал 23:4)

6. Аав аа, Японы бэлэвсэн ээжүүд болон санхүүгийн бэрхшээлтэй тулгарч буй эмэгтэйчүүдэд сүм, орон нутаг болон засгийн газар дэмжлэг үзүүлэх болтугай. (Дуулал 22:24)

7. Бурхан минь, Хойд Солонгосын нууц итгэгчдийн итгэлийг бэхжүүлээч. Тэд чөлөөтэй мөргөл өргөж, сайн мэдээг түгээх өдөр хурдан ирээсэй. (Ром 5:3-4)

8. Эзэн минь, Монгол эмэгтэйчүүдийг хүүдээ өсгөх, гэр бүлээ халамжлах болон ажлын байрны тэнцвэртэй байдлаа хадгалан хослуулан амьдрахад нь тэнхээ, эрүүл мэнд, сэтгэл санааны тэнцвэрийг нь сэргээж өгөөч. (Сургаалт үгс 31:27-30)

9. Бурхан минь, гэр бүл болон шашны хүрээнд хүртэл бэлгийн хүчирхийлэлд өртөж буй Непалын эмэгтэйчүүдэд эдгэрэл, зориг, дэмжлэгийг өгдөг нийгмийг бий болгож өгөөч. (Дуулал 34:18)

10. Аав аа, Пакистан дахь хамтран зүтгэгчид болох М болон Н нарыг хүүхэдтэй болохын төлөө залбирч байхад нь Таны ивээлээр дүүргээч. (1 Самуэл 1:27)

11. Аав аа, Тимор-Лестэд ээжүүд, хүүхдүүдийн хоол тэжээл, эрүүл мэндийн дэмжлэг сайжрах болтугай. (3 Иохан 1:2)

12. Вьетнамын эмэгтэйчүүд ядуурал болон соёлын уламжлалын улмаас бичиг үсэг тайлагдаагүй байдаг. Бурхан минь, боловсрол, бичиг үсгийн хөтөлбөр, соёлын өөрчлөлтийг Вьетнамд авчраач. (2 Коринт 9:8)

1. Эзэн минь, Афганистаны Найдвар доторх эмэгтэйчүүд хөтөлбөрийг Дари болон Пашту хэл дээр өргөжүүлж, олон эмэгтэйчүүдийг Есүсийн хайраар өөрчлөгдөх нигүүлслийг өгөөч (Матай 28:19-20)

2. Эцэг минь, Камбожийн эдийн засагт тогтвортой байдал авчирч, үнэ, цалин хөлс тогтвортой болж, ард иргэд нь гадаад руу явах шаардлагагүй байхаар Та хангаж өгөөч. (Дуулал 72:12)

3. Бид Хятад улсад гэр бүлийн хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн амь насанд заналхийлдэг асуудлыг шийдвэрлэх бүрэн хэмжээний хууль тогтоомж бий болохын төлөө залбирч байна. Эзэн, эмэгтэйчүүдийг хамгаалж,

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.